

**ХАМТАРСАН КРЕДИТ ОЛГОХ МЕХАНИЗМЫН
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ**

Ангилал	№	Нэрс	ХКОМ-ын тодорхойлолт
Ялгарлын бууралт ба ангижруулалт	1.	Хүлэмжийн хий (GHG)	Хүлэмжийн хий гэдэг нь нүүрстөрөгчийн давхар исэл (CO ₂), метан (CH ₄), азотын исэл (N ₂ O), гидрофторт нүүрстөрөгч (HFCs), перфторт нүүрстөрөгч (PFCs), хүхрийн гексафторт (SF ₆) болон азотын трифторт (NF ₃) (ХКОМ, Хэрэгжилтийн дүрэм 2-р хэсэг) зэрэг хий юм.
	2.	ХКОМ-ын төсөл	ХКОМ-ын хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах буюу ангижруулах төслийн үйл ажиллагаа (ХКОМ, Хэрэгжилтийн дүрэм 3-р хэсэг).
	3.	Кредитийн хугацаа	ХКОМ-ын төслийн батлагдсан ялгарлын бууралт эсвэл ангижруулах хугацаанд тухайн ХКОМ-ын төсөлд ХКОМ-ын кредит олгож болно. Кредитийн хугацаа гэдэг нь 10 жилийн тогтмол, эсвэл таван (5) жилийн сунгаж болох кредитийн хугацаа бөгөөд ихдээ хоёр удаа сунгаж болох ба энэ нь ХКОМ-ын төслийн хэрэгжилтийн хугацаанаас хэтрэхгүй (ХКОМ, Хэрэгжилтийн дүрэм 4-р хэсэг) .
	4.	Хамрагдах боломжтой төслийн төрлийн жагсаалт	Зөвшөөрөгдсөн аргачлалууд нь хамрагдах боломжтой төслийн төрөл эсвэл технологийн төрлийн эерэг жагсаалтыг илэрхийлнэ. (ХКОМ, Хэрэгжилтийн дүрэм 22-р хэсэг).
	5.	Тавигдах шаардлага	Сонгон шалгаруулалтад тэнцэх шалгуур нь ХКОМ-ын аргачлалд тодорхойлсноор ХКОМ-ын төсөлд тавигдах шаардлага бөгөөд дараах зүйлийг агуулна: (а) ХКОМ-ын төслөөр бүртгүүлэхийн тулд төсөлд тавигдах шаардлага; (б) ХКОМ-ын аргачлалыг хэрэглэх боломж бүхий төсөлд тавигдах шаардлага.
	6.	Хүлэмжийн хийн ялгарлын	ХКОМ-ийн төсөлд кредит тооцох ялгарлын бууралтыг жишиг ялгарал ба төслийн ялгарлын зөрүүгээр тодорхойлно. Жишиг

Ангилал	№	Нэрс	ХКОМ-ын тодорхойлолт
		цэвэр бууралт эсвэл зайлсхийх	ялгарлыг тооцохдоо хүлэмжийн хийн ялгарлыг цэвэр бууруулах/эсвэл зайлсхийх арга хэмжээ аваагүй үеийн нөхцөл (BAU)-ийн ялгарлаас доогуур тооцно.
	7.	Жишиг ялгарал	Жишиг ялгарлыг арга хэмжээ аваагүй үеийн нөхцөл (BAU)-ийн ялгарлаас доогуур тооцно. Жишиг ялгарлыг нэгж бүтээгдэхүүнд ногдох хүлэмжийн хийн ялгарлаар илэрхийлэгддэг кредитийн босго хэмжээг нийт гарцаар үржүүлж тооцно.
	8.	Арга хэмжээ аваагүй үеийн нөхцөл (BAU)	Арга хэмжээ аваагүй үеийн (BaU) ялгарал нь хэрэгжүүлэгч улсад санал болгож буй ХКОМ-ын төсөл нь ижил үр дүн эсвэл үйлчилгээний түвшнийг хангах боломжтой ялгарлыг илэрхийлнэ.
	9.	Кредитийн босго хэмжээ	Кредитийн босго хэмжээг ихэвчлэн нэгж бүтээгдэхүүнд ногдох хүлэмжийн хийн ялгарлаар илэрхийлдэг. Кредитийн босгыг хэрэгжүүлэгч улсад ижил төрлийн төсөлд ашигласан аргачлалын урьдчилсан таамаглалд үндэслэн тогтооно. Мөн арга хэмжээ аваагүй үеийн (BAU) ялгарлаас доогуур жишиг ялгарлыг тооцоолохдоо консерватив байдлаар тогтооно.
	10.	Ялгарлын эх үүсвэр ба хүлэмжийн хийн төрөл	Ялгарлын эх үүсвэрүүд болон хүлэмжийн хийн төрлүүд нь ХКОМ-ын төсөлд чухал ач холбогдолтой бөгөөд хамаатуулж болох үндэслэлтэй байна.
	11.	Шингээлт ба хүлэмжийн хийн төрөл	Шингээлт болон хүлэмжийн хийн төрлүүд нь ХКОМ-ын төсөлд чухал ач холбогдолтой бөгөөд хамаатуулж болох үндэслэлтэй байна.
	12.	Хамрах хүрээ	ХКОМ-ын төслүүдэд хамаарах салбар эсвэл бүлэг үйл ажиллагааны хүлэмжийн хийн эх үүсвэрийн ангилал. ЦХМ-ийн салбарын хамрах хүрээн дээр суурилсан. ХКОМ-ын төсөл нь нэгээс илүү салбарын хамрах хүрээнд байж болно.
	13.	Баталгаажуулалтын түвшин	Баталгаажуулалтын түвшнийг Хамтарсан хорооноос нотлохыг шаарддаг баталгааны зэрэг гэж тодорхойлно. Баталгаажуулалтын түвшнийг нотлохдоо

Ангилал	№	Нэрс	ХКОМ-ын тодорхойлолт
			ямар нэгэн орхигдуулсан, материаллаг алдаа, буруу ташаа мэдээлэл байгаа эсэхийг тодорхойлохын тулд нотлох төлөвлөгөөнийхөө нарийвчлалын гүнийг тодорхойлоход ашигладаг.
	14.	Материаллаг байдал	Материаллаг байдал гэдэг нь хувь хүний болон эсвэл алдаа, орхигдуулсан болон буруу ташаа мэдээллийн нийлэмж нь хүлэмжийн хийн баталгаажуулалт, зорилтот хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлж болзошгүй гэсэн ойлголт юм.
Засаглал	15.	Засгийн газар (талууд)	Тал тус бүр Хамтарсан Хорооноос боловсруулсан дүрэм, удирдамж болон/эсвэл улс орны дотоодын хууль тогтоомжийн дагуу ХКОМ-ыг хэрэгжүүлэхэд үндэслэсэн: (а) аргачлалын төслийг боловсруулж, Хамтарсан Хороонд мэдүүлэх; (б) Хамтарсан Хорооноос боловсруулсан бүртгэлийн нийтлэг үзүүлэлтүүдийн дагуу бүртгэлийн системийг үүсгэж, хөтлөх; (в) с) Хамтарсан Хорооноос кредит тооцох тухай мэдэгдлийг үндэслэн (төсөлд оролцогч талуудын дунд хуваарилсан кредитийг оруулан) тухайн зөвшөөрсөн хэмжээний кредитийг олгоно. Тал тус бүр ХКОМ-ын төслийн хүрээнд кредит тооцсон талаар Хамтарсан Хороонд нэн дариу мэдэгдэнэ.(ХКОМ, Хэрэгжилтийн дүрэм 14,15-р хэсэг).
	16.	Хамтарсан Хороо	Талууд ХКОМ-ыг хэрэгжилтийг ханган ажиллах хоёр талын Засгийн газрын төлөөллөөс бүрдсэн Хамтарсан Хороог байгуулна. Хамтарсан Хороо нь ХКОМ-ыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журам, удирдамжийг боловсруулж, өөрчлөлт оруулж болно. Хамтарсан Хороо нь Хөндлөнгийн магадалгаа, нотолгоо хийх гуравдагч талын этгээдийг томилно. Хамтарсан Хороо нь төсөлд оролцогчдоос

Ангилал	№	Нэрс	ХКОМ-ын тодорхойлолт
			ирүүлсэн ХКОМ-ын төслийг бүртгүүлэх хүсэлтийн үндсэн дээр Гуравдагч талын этгээдээр баталгаажсан ХКОМ-ын төслүүдийг бүртгэнэ. Төсөлд оролцогчдоос ирүүлсэн кредит тооцох талаар талуудад мэдэгдэх хүсэлтийн үндсэн дээр Хамтарсан Хороо Гуравдагч талын этгээдээр баталгаажсан кредитийг олгохыг талуудад мэдэгдэнэ. (ХКОМ, Хэрэгжилтийн дүрэм 6-10-р хэсэг).
	17.	Хамтарсан хорооны нарийн бичгийн газар	Хамтарсан Хороо нь ХКОМ-ыг хэрэгжүүлэх нарийн бичгийн газрыг байгуулж ажиллана. (ХКОМ, Хэрэгжилтийн дүрэм 13-р хэсэг).
	18.	Гуравдагч талын этгээд буюу хөндлөнгийн магадалгаа, нотолгоо хийгч байгууллага	Хамтарсан хорооноос томилсон эрх бүхий гуравдагч талын этгээд: (а) Төсөлд оролцогч талуудын хүсэлтэд үндэслэн Хамтарсан Хорооноос боловсруулсан магадалгааны удирдамжийн дагуу төсөлд оролцогч талуудын бэлдэн ирүүлсэн ТББ-д тодорхойлсон төслийг баталгаажуулан, үр дүнг төсөлд оролцогч талуудад мэдээлнэ. (б) Төсөлд оролцогч талуудын хүсэлтэд үндэслэн ХКОМ-ын төслийн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ангижруулах үйл ажиллагааг шалгах удирдамжийн дагуу төсөлд оролцогч талуудын бэлдэн ирүүлсэн хяналт-шинжилгээний тайланд тодорхойлсон ХХЯ-ын бууралт, ангижруулалтыг нотлох ажлыг Хамтарсан Хорооны боловсруулсан хяналт-шинжилгээний журмын дагуу шалгаж, үр дүнг хяналт-шинжилгээний тайланд тусган төсөлд оролцогч талуудад илгээнэ. (ХКОМ, Хэрэгжилтийн дүрэм 19-р хэсэг)
	19.	Төсөлд оролцогч талууд	Төсөлд оролцогч талууд: (а) Аргачлалын төслийг боловсруулж, төслийг Хамтарсан хороогоор батлуулах; (б) Төслийн баримт бичгийг боловсруулж, төслийг баталгаажуулахаар гуравдагч талын этгээдэд хүргүүлж, Хамтарсан

Ангилал	№	Нэрс	ХКОМ-ын тодорхойлолт
			<p>хороонд мэдэгдэх;</p> <p>(в) Төслийн баримт бичгийн төслийг Гуравдагч талын этгээдээр баталгаажуулсны дараа Хамтарсан Хороонд хүргүүлж төслийг бүртгүүлэх;</p> <p>(г) ХКОМ-ын төслийг хэрэгжүүлэх, төслийн баримт бичгийн дагуу хяналт-шинжилгээг хийх;</p> <p>(д) Хяналт-шинжилгээний тайланг бэлтгэж, тайланг баталгаажуулахаар гуравдагч талын этгээдэд илгээх;</p> <p>(е) Гуравдагч талын этгээдийн баталгаажин, нотлогдсон Хамтарсан Хороонд илгээн ХКОМ-ын кредит тооцох тухай хүсэлтийн талаар тал тус бүрд мэдэгдэх (ХКОМ, Хэрэгжилтийн дүрэм 20-р хэсэг).</p>
Баримт бичиг/бүт эц	20.	Аргачлал	<p>ХКОМ-ын төслүүдэд ашиглах аргачлал нь төсөл тус бүрээр хүрсэн ялгарлын бууралтыг тооцоолох, ХКОМ-ын төслийн хэрэгжилтэд хяналт тавина.</p> <p>Санал болгож буй аргачлал нь Хамтарсан хороогоор хэлэлцүүлэн батлуулахаар оруулсан аргачлал юм. Санал болгож буй аргачлал нь санал болгож буй аргачлалын маягт болон Санал болгож буй аргачлалын хүснэгтээс бүрдэнэ.</p> <p>Батлагдсан аргачлал нь ХКОМ-ын төслүүдэд ашиглахаар Хамтарсан хорооноос баталсан аргачлал юм. Батлагдсан аргачлал нь батлагдсан аргачлалын баримт бичиг, Хяналтын хүснэгтээс бүрдэнэ. Батлагдсан аргачлалыг ХКОМ-ын веб сайтад олон нийтэд нээлттэй байршуулна.</p>
	21.	Санал болгож буй аргачлалын хүснэгт	<p>Санал болгож буй аргачлалын хүснэгт нь аргачлалыг боловсруулсан талын санал болгож буй аргачлалын нэг хэсэг юм.</p> <p>Санал болгож буй аргачлалын хүснэгт нь хяналт-шинжилгээний төлөвлөгөөг тодорхойлж, утгыг оруулах замаар хүлэмжийн хийн ялгарлыг автоматаар тооцоолох боломжийг олгодог. Санал</p>

Ангилал	№	Нэрс	ХКОМ-ын тодорхойлолт
			болгож буй аргачлалын хүснэгт нь оролтын хуудас болон тооцооллын үйл явцын хуудаснаас бүрдэнэ.
	22.	Хяналт-шинжилгээний хүснэгт	<p>Хяналт-шинжилгээний хүснэгт нь батлагдсан аргачлалын нэг хэсэг юм. Хяналт-шинжилгээний хүснэгт нь Хяналт-шинжилгээний төлөвлөгөөний хуудас (оролтын хуудас ба тооцооллын үйл явцын хуудас), Хяналт-шинжилгээний бүтцийн хуудас, Хяналт-шинжилгээний тайлангийн хуудас (оролтын хуудас ба тооцооллын үйл явцын хуудас) зэргээс бүрдэнэ.</p> <p>Хяналт-шинжилгээний төлөвлөгөөний хуудас болон Хяналт-шинжилгээний бүтцийн хуудсыг урьдчилсан байдлаар хяналтын төлөвлөгөө боловсруулах, ялгарлын бууралтыг тооцоолоход ашиглана.</p> <p>Хяналт-шинжилгээний тайлангийн хуудсыг хяналтын тайлан бэлтгэх, ялгарлын дараах бууралтыг тооцоолоход ашиглана.</p> <p>Хяналт-шинжилгээний төлөвлөгөөний хуудас, Хяналт-шинжилгээний тайлангийн хуудсыг санал болгож буй аргачлалын хүснэгт болон хяналт-шинжилгээний бүтцийн хуудаст үндэслэн боловсруулж, Хамтарсан Хороогоор санал болгож буй аргачлалыг баталсны дараа нарийн бичгийн газраас нэмж оруулна.</p>
	23.	Төслийн баримт бичиг (PDD)	<p>ХКОМ-ын төсөлд оролцогч талуудын боловсруулсан төслийн баримт бичигт хэрэгжүүлэх гэж буй ХКОМ-ын төслийг нарийвчлан тусгасан байна. Төслийн баримт бичиг (PDD) нь Хяналт-шинжилгээний хүснэгт, Хяналт-шинжилгээний төлөвлөгөөний хуудас, Хяналт-шинжилгээний бүтцийн хуудасны дагуу бөглөсөн төслийн баримт бичгийн маягт болон хяналт-шинжилгээний төлөвлөгөөнөөс бүрдэнэ.</p> <p>Төслийн баримт бичгийн маягт, Хяналт-шинжилгээний хүснэгт болон Төслийн</p>

Ангилал	№	Нэрс	ХКОМ-ын тодорхойлолт
			баримт бичгийг бэлтгэх удирдамжийг ХКОМ-ын веб сайтад олон нийтэд нээлттэй байршуулна.
	24.	Хяналт-шинжилгээний төлөвлөгөө	Хяналт-шинжилгээний төлөвлөгөө нь ХКОМ-ын төслийн үр дүнд хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг бууруулахад төсөлд оролцогч тал болон хөндлөнгийн магадалгаа нотолгоо хийх байгууллагын хяналт-шинжилгээ хийхэд ашиглах аргачлалыг тодорхойлсон байна. Хяналт-шинжилгээний төлөвлөгөөг Хяналт-шинжилгээний төлөвлөгөөний хуудас, Хяналт-шинжилгээний бүтцийн хуудас болон Хяналт-шинжилгээний хүснэгтийг ашиглан боловсруулна.
	25.	Хяналт-шинжилгээний тайлан	Хяналт-шинжилгээний тайланг төсөлд оролцогч тал нь хяналт-шинжилгээний тодорхойлсон хугацаанд хэрэгжиж буй бүртгэлтэй ХКОМ-ын төслийн хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тусган бэлдэнэ. Хяналт-шинжилгээний төлөвлөгөөг Хяналтын хүснэгтийн дагуу Хяналтын тайлангийн хуудсыг ашиглан бэлдэнэ.
	26.	Бүртгэлийн систем	Талууд ХКОМ-ын төсөлд тооцогдсон кредитийг бүртгэх, ашиглах зорилгоор бүртгэлийн системийг байгуулна. (ХКОМ, Хэрэгжилтийн дүрэм 34-р хэсэг).
	27.	Кредит	ХКОМ-ын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах буюу ангижруулах төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд төсөлд оролцогч талуудын оруулсан хувь нэмрийн үр дүнд бууруулсан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах буюу ангижруулсан тоон хэмжээнд үндэслэн кредитийг олгоно. (ХКОМ, Хэрэгжилтийн дүрэм 3-р хэсэг). Кредитийг Уур Амьсгалын Өөрчлөлтийн асуудлаарх Засгийн Газар Хоорондын Зөвлөл (IPCC)-өөр үнэлдэг хэмжилтийн арга зүйн дагуу нүүрстөрөгчийн давхар исэлтэй дүйцэх (т/CO ₂) метр тонн-оор хэмждэг. (ХКОМ, Хэрэгжилтийн дүрэм 39-р хэсэг)

Ангилал	№	Нэрс	ХКОМ-ын тодорхойлолт
Төслийн үе шат	28.	Харилцааны арга хэлбэрийн мэдүүлэг (MoC)	ХКОМ-ын төсөлд оролцож буй төслийн оролцогч талуудын (эсвэл гарын үсэг зурсан) харилцааны арга хэлбэрийн мэдүүлэг нь тогтоосон хүрээнд тодорхойлогдсон байдаг ба тэдгээрийн нэрийн өмнөөс нарийн бичгийн газар болон Хамтарсан Хороотой харьцах томилогдсон эрх бүхий байгууллагыг томилно.
	29.	Баталгаажуулалт	Баталгаажуулалт гэдэг нь санал болгож буй ХКОМ-ын төслийн баримт бичигт үндэслэн Хамтарсан Хорооноос боловсруулсан баталгаажуулалтын журмын эсрэг хөндлөнгөөс гуравдагч талын этгээд бие даасан үнэлгээ хийх үйл явцыг хэлнэ. (ХКОМ, Хэрэгжилтийн дүрэм 25-р хэсэг)
	30.	Бүртгэл	Бүртгэл гэдэг нь баталгаажуулсан төслийг Хамтарсан Хорооноос ХКОМ-ын төсөл болгон албан ёсоор хүлээн зөвшөөрөхийг хэлнэ. (ХКОМ, Хэрэгжилтийн дүрэм 30-р хэсэг)
	31.	Хяналт-шинжилгээ	Төсөлд оролцогч талууд ХКОМ-ын төслийг хэрэгжүүлж, ХКОМ-ын төслийн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах эсвэл ангижруулах үйл ажиллагааг төслийн баримт бичигт (ХКОМ, Хэрэгжилтийн дүрэм 30-р хэсэг) үндэслэн хяналт-шинжилгээ хийнэ.
	32.	Нотолгоо	Нотолгоо гэдэг нь нотолгооны хугацаанд бүртгэгдсэн ХКОМ-ын төслийн хэрэгжилтийн үр дүнд хянагдсан хүлэмжийн хийн ялгарлын бууралт эсвэл шингээлтийг гуравдагч талын этгээд бие даасан байдлаар тогтмол хянаж, тодорхойлохыг хэлнэ. (ХКОМ, Хэрэгжилтийн дүрэм 34-р хэсэг)
	33.	Кредит олгох	Талуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд тус бүрийн бүртгэлийн дансанд Хамтарсан Хорооны мэдэгдлийн дагуу кредитийг олгоно.